



Enheten för flerspråkighet, EFF

- Улсын болон хувийн сургуулийг хоёуланг нь хамарна
- Эх хэлний хичээлийг дунд, тусгай дунд, ахлах, ахлах тусгай сургууль
- Цэцэрлэг дэх эх хэлний дэмжлэг туслалцаа
- Эх хэл дээрх сургалтын хөтөч
- Танилцуулгын туслалцаа эх хэл дээр
- Эх хэлний түвшин тогтоох
- Эх хэлний хичээл болон эх хэлний курсын шалгалт

Enheten för flerspråkighet

flersprakighet@uppsala.se

018-727 20 26



Эх хэлний хичээл



Дунд & тусгай дунд сургууль

Эх хэлний хичээлийг дунд сургуулийн турш суралцана.



Ахлах & ахлах тусгай сургууль

Эх хэлний хичээлийг курсээр судална.



Үндэсний цөөнхийн хэл

Уппсала дүүрэгт үндэсний цөөнхийн хэл эх хэлний нэг адил явагдана.



Цэцэрлэг

Цэцэрлэгийн багш нар тухайн хүүхдийн эх дэмжлэг хүсэх боломжтой.

flersprakighet.uppsala.se



Хэн эх хэлний хичээлийг сурах бэ?

(Жич: Үндэсний цөөнхийн хэлэнд хамаарахгүй)

Эцэг эхийн аль нэг нь Шведээс өөр эх хэлтэй сурагчид эх хэлний хичээлийг санал болгодог:

1. Тухайн хэл нь сурагчийн өдөр тутам гэртээ хэрэглэдэг хэл байх
2. Сурагч эх хэлний суурь мэдлэгтэй байх.

Сурагч тухайн хэлээр ярьж, ойлгодог байна. Сургалт нь үндэсний хөтөлбөрийн дагуу эх хэл дээр явагдана.

Үндэсний цөөнхийн хэл

Швед улс нь дараах цөөнхийн хэлтэй: финланд, меанкиели, сами: романи, жиддиш. Үндэсний цөөнхийн хэлийг суралцахын тулд тухайн хүн нь үндэсний цөөнхийн бүлэгт харъяалагдана. Сурагч тухайн хэлээр гэртээ ярьдаг эсвэл суурь мэдлэгтэй байх шаардлагагүй. Хичээлийн хоёр хөтөлбөр байдаг бөгөөд сурагч эх хэлээрээ ярих эсвэл анхлан суралцагчаар сурахыг суралцагч өөрөө сонгоно.

Enheten för flerspråkighet
(EFF) Уппсала дахь эх хэл
заах ажлыг зохицуулна.

Суурь мэдлэг

Цөөнхийн хэлнээс бусад бүх хэлнүүд суурь мэдлэгийг шаарддаг. Хичээлийн эхэнд багш сурагчдын суурь мэдлэгийн түвшинг тогтооно. Сонсгол болон ярианы чадварыг хоёуланг шалгана. Суурь мэдлэг гэж юу болох талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг EFF-ийн вэбсайтаас харж болно.

Өргөдөл хүсэхдээ

Сурагчийн асран хамгаалагч өргөдөл гаргана. Маягт нь сургууль болон EFF вэбсайтаас авч болно. Маягтыг бөглөөд гарын үсгээ зураад сургуульд үлдээнэ. Захирал өргөдлийг батлан хүсэлтийг EFF рүү илгээнэ, тухайн хичээлийн жилийн 6 сарын 15 сүүлийн хугацаа болно. 6 сарын 15 хойш ирсэн өргөдөлд баталгаа өгөх боломжгүй.

Хичээлийг зохион байгуулах

Уппсалад эх хэлний хичээл нь хичээлийн үндсэн цагаас гадуур явагдана. Эх хэлний хичээл ихэвчлэн үндсэн хичээл дууссаны дараа хичээлийн бус цагаар захиалагддаг. Бэлтгэл бүлгээс 5-р ангийн сурагчдын хичээл тухайн сургууль дээр явагдана. 6 -9-р ангийн сурагчдыг нэг бүлэг болгон заагдсан сургууль дээр үдээс хойш буюу орой явуулна. Сурагч нь заагдсан сургууль уруу өөрөө очно. Хэрвээ сурагч автобусны билетгүй бол эх хэлний багшид мэдэгдэж билет авна.

Дэлгэрэнгүй мэдээлэл

Уппсала хотын эх хэлний хичээлийн талаарх нэмэлт мэдээллийг EFF вэбсайтаас авч болно

flersprakighet.uppsala.se

